

Монгол улсын суурь боловсролын салбар дахь ЖАЙКА-гийн хамтын ажиллагаа

2023 оны 5 сар

Хүний хөгжлийн газар
Суурь боловсролын хэлтсийн дарга
Кобаяаши Мияако:

1. Товч намтар
2. ЖАЙКА-гийн боловсролын салбарт хэрэгжүүлж буй төслийн бодлого
3. ЖАЙКА-гийн боловсролын хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл
4. Үр дүн үзүүлсэн төслийн жишээ
5. Багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг (MALS)-с хүлээгдэх ажил

Кобаяаши Мияако: ЖАЙКА-н Хүний хөгжлийн газрын Суурь боловсролын хэлтсийн дарга

1998 онд ЖАЙКА-д орж, Японы хилийн чанад дахь залуу сайн дурын гишүүдийг хариуцсан ажлын албанд ажилласан. Улмаар Бангладеш дахь оффис, Гадаад улс дахь урт хугацаа (UNESCO)-ны сургалтанд хамрагдаж, Хүний нөөц хөгжлийн газар болон Санхүүгийн хамтын ажиллагааны газарт боловсролд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой ажил хийж байсан. 2022 оноос Суурь боловсролын хэлтсийг хариуцан ажиллаж байна.


- 2010-2012 онд Япон улсын техникийн хамтын ажиллагааны “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх, тогтолцоог бэхжүүлэх төсөл (2-р шат)”-г хариуцан ажиллаж байсан.
- 2012-2014 онд Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд “Бага боловсролын барилга байгууламжийг сайжруулах төсөл (4-р шат)”, “Бага боловсролын барилга байгууламжийг сайжруулах төсөл (2-р шат)”-н дэмжин ажиллах хэлтсийн дарга
- 2019-2021 онд Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд “Улаанбаатар хотын бага дунд боловсролын сургуулийн барилга байгууламжийг сайжруулах төсөл”, “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр (JDS)”-г хариуцсан хэлтсийн дарга



2. ЖАЙКА-гийн боловсролын салбарт хэрэгжүүлж буй төслийн бодлого

Глобал хөтөлбөр (Сэдэвчилсэн төслийн стратеги) **「Боловсрол」**

- Хүн бүр эрх тэгш боловсрол эзэмших үндсэн эрхтэй. Энэ нь нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийн суурийг тавьдаг.
- ЖАЙКА Япон улсын хөгжлийн үндэс болж ирсэн чанартай боловсролыг түгээн дэлгэрүүлэх туршлага, мөн системтэй сурах бичиг, сургалтын материал, хичээлийн судалгаатай багшийн сургалтын систем, асран хамгаалагч, орон нутгийн нийгмийн дэмжлэг оролцоотой төсөл хэрэгжүүлэх туршлагадаа үндэслэн суурь боловсролын салбарт дараах **гурван чиглэл (кластер)-г** тодорхойлсон.



- **Зорилт:** Чанартай боловсролыг олгох боломж бий болгосоноор, хүн бүр өөрийн авьяас, ур чадвараа бүрэн хөгжүүлж, нэр төртэй амьдрах нийгмийн суурийг тавьж, улмаар нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжинэ.
- **Гол үзүүлэлт:** 2030 он хүртэлх дараах зорилтод хүрч, Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн 4 дэхь зорилгод хувь нэмрээ оруулна.



Суурь боловсролын салбарын үзүүлэлт

Боловсролын чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлснээр 20 сая хүүхэд үр өгөөжийг хүртэнэ. Улмаар гадны байгууллагатай хамтран ажилласнаар 40 сая хүүхэд үр өгөөжийг хүртэнэ.

Амжилттай хэрэгжсэн төслөөр математик-н сурах чадвар сайжирна.

Охид ба эмзэг бүлгийн хүүхдүүдийн сургуульд хамрагдалт, суралцах нөхцлийг сайжруулахад чиглэсэн боловсролыг дэмжих арга замыг хөгжүүлснээр 3 сая хүүхэд үр өгөөжийг хүртэх боломжтой.

3. Боловсролын хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл

Үндэслэл: Тогтвортой хөгжлийн зорилго 4-д чиглүүлж КОВИД 19-н улмаас 『Боловсролын ядуурал』-г арилгахад хувь нэмрээ оруулна.

1. Шинэлэг зүйл: DX

- ◆ КОВИД 19-н дараах “Олон улсын нийтийн бараа”-г түгээн дэлгэрүүлж, ашиглах <https://www.jica.go.jp/activities/issues/education/materials/index.html>
- ◆ Программ хангамж (Математик сурах аппликейшн ба одоо хэрэгжлэж буй сургалтын материалыг хөгжүүлж, EMIS гэх мэт дата мэдээг бэлтгэх) ба техник хангамж (Алсын зайн сургалтын тоног төхөөрөмжийн багц) хослол

2. Дэлхийн хөтөлбөр (GA)-г тодорхой болгох

- Дэлхийн хөтөлбөрт тулгуурлан санхүүгийн хамтын ажиллагаа (буцалтгүй тусламж, иений хөнгөлттэй зээл) × Техникийн хамтын ажиллагаа

3. Үр дүнг харуулах хэлбэр

- Японы ерөнхий сайд Кишида Фүмиог “Боловсролын аварга”-р томилсон. Улмаар 2023 оны 5-р сард зохион байгуулагдсан Их долоо бүлгийн Боловсролын сайд нарын чуулга уулзалтад хандаж үндсэн төсөл “Үр дүнг ойлгомжтойгоор харуулах” (Тоон үзүүлэлтээр үр дүнг дүрслэн харуулахыг дэмжих)-г уриалсан.

4. Нэмүү өртөг бий болгох


- Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг (MALS) гэх мэт байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож, үнэт цэнийг бий болгох

5. Хамтын ажиллагааны нөлөө

- Бусад донор, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшил, NGO/NPO-н хамтын ажиллагаа

Эль Сальвадор улсын "Бага дунд боловсролын математикийн хичээлийн заах арга зүйг сайжруулах төсөл (ESMATE)"-н хүрээнд боловсруулсан сурах бичгийг тараах гэх мэт туслах багцаар математикийн сургалт хэрхэн сайжирсныг шалгахад хичээлийн 2 жилийн хугацаанд RCT-р нөлөөллийн үнэлгээг хийсэн. Энэхүү ажлын хүрээнд бага сургуулийн 2-р ангийн сурагчдыг хамруулахад судалгааны эхний жилд математикт суралцах үр дүн үнэлгээний ялгааны үзүүлэлтээр 4.9-р дээшилсэн.

Үр дүнг улаан өнгөөр, харьцуулах үзүүлэлтийг цэнхэр өнгөөр



4 Үр дүн үзүүлсэн төслийн жишээ

②: Мадагаскар улс”Бид бүхний сургууль”

Мадагаскар улсад хэрэгжүүлсэн ”Бид бүхний сургууль”төслийн тухай 9-р сарын 9 өдрийн **Financial Times-д нийтлэгдсэн.**

Гэйтсийн сангийн дэмжлэгээр АНУ-н судалгааны байгууллага (Research Triangle Institute International) Латин Америкийн ESMATE төсөл болон Африк, Азийн бүс нутгийн математикийн салбарт амжилттай хэрэгжсэн зургаан хөтөлбөрийг сонгосон.

= Улмаар амжилттай хэрэгжсэн зургаан төслийн хоёр нь ЖАЙКА-гийн боловсролын төсөл байсан.


[Numeracy levels deserve same focus as literacy in low-income nations | Financial Times \(ft.com\)](https://www.ft.com/content/numeracy-levels-deserve-same-focus-as-literacy-in-low-income-nations)

Суурь чадвар (унших, бичих, бодох)-г дээшлүүлэх


2021-2022学年度：読み書きテスト結果

長文が読める生徒の割合

7県6,758校、生徒759,156名(2 - 5年生)



2021-2022学年度：算数テスト結果 アムルニマニア県906校、生徒81,476名 (2-5年生)



4 Үр дүн үзүүлсэн төслийн жишээ ③: Монгол улсын санхүүгийн хамтын ажиллагаа, техникийн хамтын ажиллагааны төслийн уялдаа холбоо

Нэмүү өртөг шингэсэн сургууль, багшийн сургуулийг барих

✓ ЖАЙКА-гийн давуу тал болон хамтын ажиллагааны чухал хэсэг

Техникийн хамтын ажиллагаагаар хүртээмжийг нэмэгдүүлсэн, хүрээлэн буй орчин, гамшгаас хамгаалах гэх мэт нэмүү өртөг шингэсэн загвар сургуулийг байгуулах

Суурь судалгаа “Бага дунд сургуулийн байгууламжийг байгуулахад нэмүү өртөгийг нэмэгдүүлэх хандивлагчийн схемийн харьцуулах дүн шинжилгээ”

- Тэгш хамруулах (охид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих)
- Гамшгаас хамгаалах (орон нутгийн нүүлгэн шилжүүлэх газар, нүүлгэн шилжүүлэх сургалт, нөөц эрчим хүчний эх үүсвэр, нөөц усны танк, нөөц санг байгуулах)
- Хүрээлэн буй орчин (Дулаан тусгаарлагч, LED гэрэлтүүлэг, өндөр үр ашигтай уурын зуух)

✓ Жишээ


Тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан сургуулийн байгууламжийг барих (буцалтгүй) төсөл ба Тэгш хамруулах боловсрол START 2 (Хамтын ажиллагаа) төслийн уялдаа холбоо

➤ Монгол улс “Улаанбаатар хотын бага дунд боловсролын барилга байгууламжийг барих төсөл” (2017 онд гэрээг байгуулсан)

※Сургуулийн барилга хүртээмжтэй, орон нутгийн гамшгаас хамгаалах бааз болгож ашиглах боломжтойгоор галд тэсвэртэй хаалга, нөөц сангаар тоноглогдсон. Улмаар агаар битүүмжлэлийг сайжруулж, байгаль орчинд ээлтэй уурын зуухыг ашиглаж, эко техникийн үзүүлэлттэйгээр хийсэн.



高窓からの採光を確保して半地下階を利用した特別教室（ICT教室、技術実習室、多目的教室）



技プロ「モンゴル国障害児のための教育改善フェーズ2（START 2）」実施中

▲カ...クラブが作成した障害理...番組

5 Багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл Хичээлийн судалгааны нийгэмлэг (MALS)-с хүлээгдэх ажил

✓ ЖАЙКА-гийн техникийн хамтын ажиллагааны “Багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл” (2006-2013 он) -н үнэт зүйл

- Багш нар харилцан суралцах, хичээлийн судалгаа→ЖАЙКА “Суралцахуйг сайжруулах”
Арга барилын тулгуур
- Мэдлэг дамжуулах сургалтаас хүүхэд төвтэй сургалт руу шилжинэ.
- Мөн нийслэл хот төдийгүй Завхан аймаг гэх мэт алслагдсан газарт багшийн манлайлалыг бий болгосон.
- 10 гаруй жилийн өмнөөс DX/ICT ашиглаж байна.
- Техникийн хамтын ажиллагааны төсөл дууссаны дараа БШУЯ тогтолцоог бэхжүүлж, системийг бүрдүүлсэн бөгөөд Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг (MALS)-ийг 2013 онд байгуулсан.
→Бусад улс орнуудад амжилттай хэрэгжсэн практик



✓ MALS-с хүлээгдэх ажил

- Япон багш нар (Токио Гакугэй их сургуулийн професор Камата, профессор Мацүүро)
ЖАЙКА-гийн мэргэжилтэн (Сузуки, Иши)-тэй хамтын ажиллагаагаа үргэжлүүлж байна.
- Эрдэм шинжилгээний нийгэмлэг, судалгааны байгууллагын хамтарсан судалгаа хийж, мэдээллэж байна.
→Энэ удаагийн семинараар **монгол талын өөрсдийн идэвх зүтгэлээр гаргасан үр дүнг түгээн дэлгэрүүлж, өргөжүүлэх ажлыг дахин эрчимжүүлж, цаашид Монгол тал бие даан хөгжүүлнэ.** →ЖАЙКА-тай ажиллах цаашдын хамтын ажиллагааг судлаж үзнэ.



Анхаарал тавьсанд баярлалаа.